

ПРОБАЦЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨН ЧАНАР, ОНЦЛОГ

CHARACTERISTICS OF PROBATE PROCEEDINGS



Д.Буяаннэмэх

Сургаалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Ял эдлүүлэх эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), хошууч

Хүний эрхийг хүндэтгэн дээдлэх болсон өнөө цаг үед аливаа улс орон ялын бодлогоо энэрэнгүй, хүнлэг болгон шинэчлэх, ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх тогтолцоог шинэ шатанд гаргах чиглэлд анхаарч байгаатай уялдан хорих ялыг аль болох сонгох хувилбартай ялыг сонгон хэрэглэх асуудал чухалд тооцогдох болсон.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс дэлхийн олон улс оронд уламжлал болсон хорих ялын тогтолцоо бат бөх оршсоор байгаа нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорьж цагдах, эрх чөлөөг нь хасах, хязгаарлах зэргээр хүний эрхийг зөрчих үндсэн шалтгаан болж байна гэж үзжээ. Учир нь олон улсын практикаас үзэхэд шоронгийн нөхцөлд хүнийг засаж хүмүүжүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга нь үр нөлөө багатай байгаагийн дээр нийгэмд төдийгүй хувь хүний төлөвшилд сөрөг үр дагавартай болох нь нэгэнтээ нотлогджээ¹.

Хорих ял нь дараах сул талыг агуулж байна. Үүнд:

а) хорих ялын хувьд “нийгэмшүүлэх” ба “цээрлүүлэх” гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Цээрлүүлэх хэлбэр нь цээрлүүлэх гэсэн агуулгаар бус тодорхой нөхцөл, журмын хүрээнд хүний эрхийг хязгаарлан, шүүхээс тогтоосон хугацаагаар хорьж буй байдлыг илэрхийлнэ. Энэ утгаараа хорих ялд хүмүүжлийн гэхээсээ илүүтэй цээрлүүлэх шинж давамгайлна. Хорих

¹ Compendium of conventions, recommendations and resolutions relating to penitentiary questions. Strasbourg: Council of Europe Publishing, 2009. p. 171.

газарт хэрэгжүүлж байгаа аливаа үйл ажиллагаа нь чөлөөт сонголтын бус албадлагын хэлбэрээр явагдах ба хоригдлыг нийгмээс тусгаарлан хүмүүжүүлнэ гэдэг өнөөгийн нөхцөлд боломжгүй, хүндрэлтэй;

б) хорих ялд хүнлэг бус шинж чанар давамгайлдаг, өөрөөр хэлбэл хорих дэглэм нь цээрлүүлэх аргад тулгуурлах тул хоригдлын зүгээс аливаа чөлөөт үйлдэл хийх, авьяас чадвараа хөгжүүлэх боломж хязгаарлагдмал;

в) хоригдлын Үндсэн хуулиар тогтоосон зарим эрх, эрх чөлөө хязгаарлагдана;

г) хорих ял эдлэх нөхцөлөөс шалтгаалан нийгэм, ар гэр, хамт олноосоо тусгаарлагдана;

д) хоригдолд бусад хоригдлын зүгээс дарамт шахалт, сөрөг муу нөлөө үзүүлснээс засарч хүмүүжүүлэхээс илүүтэй мэргэшлийн гэмт хэрэгтэн болох магадлалтай юм.

Эдгээр хүчин зүйлс нь хоригдлын хүмүүжил, зан үйл, сэтгэл санаа, бие бялдар, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ түүнийг нийгэмшүүлэхэд хүндрэл үүсгэдэг. Учир нь нийгмийн зүгээс хорих ялыг гол төлөв эергээр хүлээн авдаггүй тул хорих ял эдэлсэн хоригдлын амьдралд болон гэр бүлийн гишүүдийн насан туршийн хар толбо үлддэг.

Олон улсад сүүлийн 2 жилд хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад дараах хүндрэлтэй асуудал тулгараад байна. Үүнд:

1. Эрүүгийн ял, ялын гүйцэтгэлийн бодлогын уялдаа холбоо, тухайлан, давтан гэмт хэргийг бууруулах асуудал;

2. Хорих байгууллагын эрүүл мэндийн үйлчилгээ, “COVID-19” цар тахлын эсрэг хариу арга хэмжээ;

3. Бүс нутаг, тодорхой улс орныг хамарсан дайн тулаан, нийгмийн тогтворгүй байдал, байгалийн гамшиг;

4. Хорих байгууллагын хүний нөөцийн асуудал, тухайлан, хоригдлыг нийгэмшүүлэх чиглэлээрх олон нийтийн оролцоо;

5. Хорих байгууллагын санхүүжилт хангалтгүй, жишээ нь: Камбож, Төв Африкийн Бүгд Найрамдах улс зэрэг улсад хоригдолд өдөрт 1 доллар хүрэхгүй зардал оногдож буй нь хорих орчин нөхцөл муу, эрүүл мэндийн үйлчилгээний хомсдолд хүргэсэн;

6. Эмэгтэй хоригдлын эрх, тэр дундаа хорих ангид төрсөн ээжтэйгээ цуг байгаа хүүхдийн асуудал;

7. Хорих байгууллага дахь аюулгүй байдлыг хангах арга хэмжээний доголдол, хоригдлын зүгээс үйлдэж буй гэмт хэрэг, хүчирхийлэл, нас баралт (хорих ангид үйлдэгдэж буй нийт гэмт хэргийн 50-аас дээш хувь нь хүчирхийллийн шинжтэй, 7% хүн алах, 20% нь мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг) ихэссэн;

8. Хорих ангид хоригдож буй тодорхой бүлгийн (хөгжлийн бэрхшээлтэй, лесби, гей, бисексуал, трансжендер ба интерсекс хоригдол) эрхийн асуудал зэрэг байна¹.

Дээрх хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх хүрээнд улс орнуудын Засгийн газар, бодлого боловсруулагчдаас хорих ял эдлэгсдийн тоог бууруулах, хорихоос өөр төрлийн ял, арга хэмжээний үр дүнтэй хэлбэрийг нэвтрүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна.

Гэмт хэрэг үйлдсэн хүн бүрд хорих ял оногдуулах нь төдийлөн оновчтой сонголт биш юм. Хорихоос өөр төрлийн ял буюу олон улсад алтернатив гэж нэрлэгддэг ял нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг шүүхээр тогтоосны дараа нийгмээс тусгаарлаж, хорихгүйгээр тодорхой эрхийн хязгаарлалт тогтоох хэлбэрээр хэрэгжиж байна.²

Судалгааны ажлыг хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж буй пробацын үйл ажиллагааны мөн чанарыг нээн илрүүлэхийн тулд ойлголт, шинжийг тодорхойлох нь зүйтэй гэж үзлээ.

Пробац (probation) гэсэн нэр томъёо нь “probatio” гэсэн латин үгнээс гаралтай, туршилт, ажиглалт явуулах гэсэн нэршил юм. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорих ял оногдуулж, нийгмээс тусгаарлахгүйгээр олон нийтийн дунд хяналтын болон нийгэмшүүлэх арга хэмжээг зохион байгуулах нөлөөллийн арга хэмжээ гэж ойлгож болно.

Энэхүү ойлголтыг шүүхээс гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорихгүйгээр нийгэмд нь хянах, турших, боломж олгох үйл ажиллагааг төрийн

¹ Алтангэрэл, Б. Олон улсын ял эдлүүлэх ажиллагааны чиг хандлага. Хууль сахиулахуй. 2022. № 3.

² Очгэрэл, Ц. Торгох ялын хэрэгжилт ба түүний хэрэгжилтэд анхаарах асуудал. //Хууль сахиулах үйл ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2017. №1

байгууллагаас хянах буюу ажиглах гэсэн утгыг илэрхийлж байна гэж үзэж байна.

Олон улсад пробац, парол гэдэг нэр томъёог хамтатган хэрэглэх тохиолдол байдаг. Энэ нь үйл ажиллагааны хувьд ялгаатай ба пробац нь хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээний хяналтыг хэрэгжүүлдэг тогтолцоог, парол нь хорих ялын хугацаа дуусаж болон хугацааны өмнө суллагдсан этгээдэд тавих хяналтын тогтолцоог хэлнэ.

Судлаачийн зүгээс пробацыг эх хэлнээ хөрвүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзвэл, хянан харгалзах (хянах гэдэг нь үйл ажиллагааны тогтолцоо, харгалзах гэдэг нь тодорхой гэмт хэрэг үйлдсэн этгээдэд чиглэсэн үйлчилгээ) гэж тайлбарлаж болох юм.

Пробацын үйл ажиллагаа гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр гэмт зан үйлийг өөрчлөх, нийгмийн амьдралд дасан зохицоход чиглэсэн үйлчилгээ үзүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд болон хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад мэргэшсэн гэмт хэрэгтэн бие хүн болж өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Европын улс орнуудад XIX дүгээр зууны сүүлч буюу 1872 онд Англи, 1887-1930-д оны хооронд Бельги, АНУ-ын ял эдлүүлэх ажиллагаанд хөгжиж иржээ.

Пробацын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн болон ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээг сахиж мөрдүүлэх, улмаар нийгэмшүүлэхэд оршдог бол үйл ажиллагааны үндсэн шинж нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорихгүйгээр тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын мэдэлд шилжүүлэн хяналт тогтоон, нийгэмшүүлж буй шийтгэлийн нэг хэлбэр юм.

П.К.Фрайдийн үзэж байгаагаар пробац нь эрх зүйт төрийн тогтолцоотой улс оронд бий болж, төлөвших өндөр магадлалтай гэжээ¹. Түүнийхээр ял шийтгэл нь залхаан цээрлүүлэх хэрэгсэл болохын хувьд ялын зорилгыг тодорхойлдоггүй тул гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн хэрэгсэл болдоггүй. Учир нь гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд хувийн зан чанар, зан үйлийн төлөвшил болон нийгмийн хүчин зүйл нөлөөлдөг гэжээ.

¹ Friday P.C. 1979. Critical Issues in Adult Probation. Washington, D.C.: International Assessment of Adult Probation, p.73.

Дэлхийн улс орнуудын пробацын үйл ажиллагаанд дараах ижил төстэй тал байна. Үүнд:

Нэг. Пробац нь хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ болох тухай:

Манай улсад хэрэглэгдэж буй хорихоос өөр төрлийн ял гэх нэр томъёо нь дэлхийн улс орнуудад:

1. Нийгэм-олон нийтэд тулгуурласан ял нь (community sentence, community based sentence¹);

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэгдэж буй сонгох ял (alternative sentence);

3. Хорихоос өөр төрлийн ял (non-custodial sentence)-ын нэгэн адил хэрэглэгдэх нэгдмэл нэршил бүхий ойлголт² юм.

Нийгмээс тусгаарлахгүй ял, сонгох хувилбараар оноох ял гэсэн ойлголт зарчмын хувьд ижил утгыг илэрхийлнэ. Сонгох хувилбараар оноох гэдэгт нийгэмд учруулсан аюул занал, хохирлын хэмжээг харгалзан гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эдлэх ялыг нийгмээс тусгаарлах шинжгүй ялаар орлуулан хэрэглэж буй төрийн албадлагын арга хэмжээг ойлгоно. Хорихоос өөр төрлийн ялыг дэлхийн ихэнх улсад нийгмээс тусгаарлахгүйгээр ял гэж нэрлэж байна.

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа нь гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх, үйлдсэн хор уршгийг арилгах боломжийг илүү олгодог бөгөөд ялын уламжлалт онолын хандлага буюу зөвхөн цээрлэл үзүүлж шийтгэх явдлыг эрс шүүмжилсэн, нийгэм-олон нийтэд ил тод, нээлттэй байх, тэдний оролцоо, дэмжлэг тусламжид тулгуурласан, эдийн засаг, нийгмийн үр өгөөжтэй ял эдлүүлэх тогтолцооны шинэ хэлбэр гэж үзэж байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд юуны өмнө ялын төрөл, хэлбэрийг илүү боловсронгуй болгох шаардлагатай. Учир нь өнөөг хүртэл гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорих арга барил хууль сахиулах, шүүхийн практикт бат бөх оршсоор байна. Иймд олон нийтийн зүгээс эрүүгийн ялын бодлогыг илүү хүнлэг, энэрэнгүй,

¹ Зарим судлаачид “нийгэмд үйлчлэх ял”, “нийтийн тусын тулд үйлчлэх ял” зэргээр нэрлэх нь бий.

² www.gov.uk.

ардчилсан хэлбэрт шилжүүлэх арга замыг тууштай эрэлхийлсээр байна. Эдгээр арга замын нэг нь нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял буюу хорихоос өөр төрлийн ял гэж үзлээ.

Нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял нь ялтны зарим эрхийг тодорхой болзол, нөхцөлтэйгөөр хязгаарлах замаар оноож буй ялыг ойлгох ба гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн зан байдал, зан үйл, ёс суртахууны төлөвшил, үйлдсэн гэмт хэргийн шинж, учруулсан хохирлын хэмжээ, гэм буруугийн хэлбэр зэрэг олон хүчин зүйлсийг харгалзаж оногдуулдаг байна.

Нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ялын давуу тал нь:

1. Хүнлэг ёсны үзэл санаа давамгайлсан;
2. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх олон талын арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой;
3. Хүний үндсэн эрх, эрх чөлөөний хязгаарлалт нь хорих ялтай харьцуулахад сул, хувь хүнд үлдээх сөрөг үр дагавар багатай;
4. Хорих ялтай харьцуулахад эдийн засгийн хувьд хэмнэлттэй зэрэгт оршино.

Олон улсад ялын сонгох хувилбарын хүрээг тэлж өргөжүүлэхийн тулд юуны өмнө тухайн орны эрүүгийн болон ял эдлүүлэх ажиллагааны тухай хуульд¹ нийгмээс тусгаарлахгүй ялыг² түлхүү тусгадаг туршлага байна. Түүнчлэн ял оногдуулах зарчимд тодорхой санкцыг хуульчлан, оногдуулахаас аль болох зайлсхийх, сонгох боломжит шийдлээр зохицуулах, хүнд биш хэргийн хувьд тэнсэх, торгох ялыг хэрэглэх, баривчлах болон хорих ялын доод хугацааг багаар тооцох, торгуулийг сүүлийн 6 сар хүртэлх сарын дундаж орлогоор тооцох, мөнгөн дүнгээр илэрхийлэх, хорихоос өөр төрлийн ялыг өргөжүүлэн, ял солих процедурыг оновчтой хэрэглэх практик түгээмэл хэрэглэгдэж байна³.

Эрүүгийн эрх зүйн салбарт глобалчлал, интеграцчиллын үйл явц нэвтэрч эхэлсэнтэй холбоотойгоор дэлхийн хэмжээний эрүүгийн загвар хууль гаргах, олон улсын хэмжээнд дагаж мөрдөх ялын бодлогын үзэл баримтлал боловсруулах ажил 2003 оноос эрчимтэй өрнөж байна. Үүний үр

¹ Монгол Улсын хувьд уг хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай гэж нэрлэсэн байна.

² Монгол Улсын хувьд уг ялыг “хорихоос өөр төрлийн ял” гэж нэрлэсэн байна.

³ Алтангэрэл, Б. Эрүүгийн ялын гүйцэтгэлийн үр нөлөөнд хийсэн дүн шинжилгээ судалгааны ажлын тайлан. -Уб., 2018.

дүнд 2007 онд НҮБ-ын болон харьцуулсан эрүүгийн эрх зүй судлалын олон улсын хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр В.Коннор, С.Раушь нарын редакторлаж, олон улсын шинжээч, судлаач, эрдэмтдийн оролцоотой гаргасан Дэлхий дахины эрүүгийн загвар хууль гарчээ.

Энэ загвар хууль 17 бүлэг, 200 зүйл, 300 шахам тайлбарыг өөртөө багтаасан 526 хуудас бүхий томоохон хэмжээний чухал хэрэглэгдэхүүн болжээ¹.

Ялын бодлогын хувьд загвар хууль аль нэг системийн онцлогийг тусгаагүй, харин дундын буюу жишгийн зарчим, хандлага түлхүү тусгагджээ. Ялын төрлийг үндсэн, сонгох, нэмэлт гэсэн гурван ангиллаар авч үзэн, үндсэн төрөлд бүх насаар нь хорих, хугацаатай хорих, торгох, сонгох төрөлд шүүхийн тогтоол гүйцэтгэхийг хойшлуулах, нийгмийн үйлчилгээнд хамруулах, гэрийн хяналтад байлгах, нэмэлт төрөлд торгууль, нөхөн төлбөр, эрх хасах, хянан харгалзах, үйл ажиллагаа, албан тушаал эрхлэхийг хориглох, эх орноосоо албадан гаргах зэрэг ялыг багтаажээ.

Ял оноохдоо тухайн гэмт хэргийн хор аюул, гэм буруу, хор уршиг, яллагдаж буй этгээдийн засрах боломж болон нийгмийн шударга ёс сэргээгдсэн эсэхийг харгалзан оновчтой шийдэж байх нөхцөлийг заажээ. Ял нь хууль тогтоомжид эрх зүйн үндэслэлийн хувьд тодорхой томъёологдсон байхаас гадна хуулиас гадуур хэнийг ч яллаж, шийтгэж болохгүй тухай өгүүлсэн нь бий.

Хүснэгт 1. Дэлхийн Эрүүгийн загвар хуульд тусгагдсан ялын төрөл.

Ялын төрөл		
Үндсэн	Сонгох	Нэмэлт
Бүх насаар нь хорих	Шүүхийн тогтоол гүйцэтгэхийг хойшлуулах	Торгууль, нөхөн төлбөр
Хугацаатай хорих	Нийгмийн үйлчилгээнд хамруулах	Эрх хасах, хянан харгалзах

¹ Model Codes for Post-conflict Criminal Justice Model Criminal code. Vivienne Conner and Colete Raush editors, Peasbuilding and the Rule of law. W,P,L, 2007.

Торгох	Гэрийн хяналтад байлгах	Үйл ажиллагаа, албан тушаал эрхлэхийг хориглох
		Эх орноосоо албадан гаргах

Өнөө цаг үед дэлхий дахинд ялын бодлогод дараах өөрчлөлт хийгдэж байна. Үүнд:

- цаазаар авах ялыг халах (одоо 99 улсад бүрэн халсан, зөвхөн 58 улсад хэрэглэдэг);

- бие махбодын шийтгэлээс татгалзах;

- цөллөгийн хөдөлмөрийг халах (Европ, Ази тивийн олон улс, АНУ-ын хууль тогтоомжоос хассан);

- нийт хөрөнгө хураах ялаас татгалзах;

- хорихоос өөр төрлийн ял хэрэглэх (торгууль, албадан ажил, тэнсэн, нийтэд тустай ажил, гэрийн хорио);

- эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэлийг нэмэх (хохирогчтой эвлэрсэн, аргагүй хамгаалалтын хэмжээ хязгаарыг өргөтгөсөн, хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвар гэсэн ойлголт бий болсон);

- насанд хүрээгүй гэмт хэрэгтний эрүүгийн эрх зүйн дэглэмийн хэрэгжилтийг өргөтгөх;

- олон үйлдлийг гэмт хэрэгт тооцохоо больж, захиргааны зөрчлийн хэмжээнд авч үзэх (жигжиг хулгай, танхай, үр хөндөх г.м¹).

Зарим улс ялын төрлийг тогтоохдоо хүмүүнлэгийн чиглэлийн хүрээнд өөрчлөлт хийж эхэлсэн ба баруун Европын дийлэнх улс, орон цаазаар авах ялыг халж, албадан ажил хийлгэх, эд хөрөнгийг бүхэлд нь хураах ялыг хязгаарлан, нийгмийн үйлчилгээ, хөтөлбөрт хамруулах, нөхөн төлбөр төрлөөр сольж, ялын бодлогодоо өөрчлөлт оруулсаар байна.

Монгол Улсын хувьд өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй 2015 оны Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагын зорилгод нийцүүлэн гэмт

¹ Болдбаатар Ж. Эрүүгийн ялын бодлогын шинэчлэлт. // Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2018. №3.

хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хорих ял тэнссэн, эсхүл хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүнд шүүх үндсэн ялаас гадна тодорхой үүрэг хүлээлгэх, эрхийн хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэхээр заасан. Тухайлбал, гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авах, зан үйлээ засах, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад хамрагдах, тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх, тодорхой газар очих, тодорхой хүнтэй харилцахыг хязгаарлах, галт зэвсэг өмчлөх, эзэмшихийг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглох, тодорхой үйл ажиллагаа явуулахыг хориглох зэрэг арга хэмжээ нь олон улсын пробацын үйл ажиллагаанд хамаарах чиг үүрэг адил байна гэж үзэж болно.

Хорихоос өөр төрлийн буюу нийгмээс тусгаарлахгүйгээр ял эдлүүлэх нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорих газарт хорихгүйгээр, ар гэр, амьдралд нь байлган нийгэмшүүлэхэд чиглэгдсэн ялын зорилгыг хангахад чиглэгдсэн төрийн албадлагын арга хэмжээ гэж дүгнэлээ.

Хоёр. Пробац нь ялын гүйцэтгэлийг хангах тогтолцоо болох тухай:

Олон улсад пробацыг хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, хорих ял тэнссэн, хойшлуулсан, хорих ангиас суллагдсан этгээдэд хяналт тавьж буй тогтолцоо буюу ялын гүйцэтгэлийг хангах бие даасан тогтолцоо гэж үзэх хандлага байна. Тухайлбал, А.У.Садыковын үзэж байгаагаар пробац нь бие даасан ялын төрөл гэж үзэн дараах хэв шинжийг агуулдаг гэжээ. Үүнд:

- ял шийтгэлийн төрөл;
- гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хүмүүжүүлэх арга, хэлбэр;
- ялын гүйцэтгэлийг хэрэгжүүлэх тогтолцоо;
- нийгэм, эрх зүйн хүрээнд хяналт тогтоох хэлбэр;
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
- гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх хэрэгсэл ¹ гэж тодорхойлсон байна.

¹ Учебник. Уголовно-исполнительное право. Под ред. Шмарова И.В. Москва: Бек, 1996.

АНУ, Англид пробац нь шүүхээс тогтоосон туршилтын хугацаанд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тусгай байгууллагын хяналтад байлгахгаар шилжүүлж буй тэнсэн харгалзах ялын төрөл, ял эдлэх хугацаанд шүүхээс заасан газар нутагт зорчих, тодорхой хүнтэй уулзаж, харилцах эрхийг нэмэлтээр хязгаарлаж болдог байна.

Олон улсын практикт пробацын үйл ажиллагааны чиглэл, агуулга нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

- тэнсэгдсэн этгээдэд тавих хяналт;
- нийтэд тусгай ажил хийлгэх ялын хэлбэр;
- хорих ял хойшлуулсан, шүүхээс тодорхой төрлийн эрхийн хязгаарлалт тогтоосон нөхцөл;
- зорчих эрхийг хязгаарлах ялын хэлбэр;
- хорих газраас суллагдсан хүмүүст нийгмийн амьдралд ороход туслалцаа үзүүлэх, нийгэмшүүлэх;
- насанд хүрээгүй этгээд гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд;
- гэмт хэрэгт шалгагдаж байгаа хүнд туслалцаа үзүүлэх;
- гэмт хэрэг үйлдсэн хүнийг хохирогчтой эвлэрүүлэх, зуучлах зэрэг чиглэлээр ажиллаж байна.

Пробац нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхийн тулд оноосон хорихоос өөр төрлийн ял буюу сонгох хувилбартайгаар хяналт тогтоох арга хэмжээг хэрэгжүүлж буй хөтөлбөр бөгөөд энэхүү хөтөлбөр, тогтоосон дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд хорих байгууллагад шилжүүлж, ялыг биеэр эдлүүлдэг байна.

Пробац нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр засаж хүмүүжүүлэх зорилготой ялын төрөл тул хяналтын хугацаанд өмнө эрхэлж байсан ажлын байраа хэвээр хадгалан үлддэг. Тухайлбал, пробацын байгууллагын зүгээс гэмт хэрэг үйлдсэн хүнд хууль, эрх зүйн мэдлэг олгох, хүмүүжил төлөвшил суулгах, соён гэгээрүүлэх, мэргэжил олгох чиглэлээр бүх хэлбэрийн сургалтыг тусгай хөтөлбөрөөр зохион байгуулахын зэрэгцээ архи, мансууруулах бодисын донтолт зэрэг гаж зуршлыг засах эмчилгээнд хамруулдаг.

Улс орон бүр эрх зүйн зохицуулалтын онцлог, нийгэм, эдийн засгийн байдал, хүн амын өсөлт хөгжил, боловсрол, эрүүл мэнд, гэмт хэргийн гаралт зэрэг хүчин зүйлээс хамаарч ял эдлүүлэх байгууллагын бүтэц, тогтолцоо харилцан адилгүй байх хэдий ч дэлхий нийтээр хорихоос өөр төрлийн ялыг сонгон хэрэглэх болсон энэ цаг үед харилцан туршлага судлах, ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч байна. (Хавсралт 4-өөс үзнэ үү)

Пробацын тогтолцоо бүхий улс орнуудын хувьд эрүүгийн бодлого, хэрэгжүүлэгч байгууллага нь төрийн тусгай байгууллага байх тогтолцоо давамгайлдаг хэдий ч хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх байгууллага нь олон нийтийн оролцоонд тулгуурлах, хяналт тавих нөхцөлийг бүрдүүлсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгосон сайн туршлага байна.

Пробацыг ялын гүйцэтгэлийг хангах тогтолцоо гэж үзэх дараах 3 хэлбэр байна. Үүнд:

1. Төрийн ялын бодлогыг хэрэгжүүлэгч болохын хувьд:

Эрүүгийн ялыг тогтоосон эрх зүйн зохицуулалт, ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд тулгуурлан ялын гүйцэтгэлийн бодлого тодорхойлогддог. Эрүүгийн ялын гүйцэтгэлийн бодлого гэдгийг төрийн зүгээс эрүүгийн ялын зорилгыг тодорхойлох, эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах болон шүүхээс ял оноосон этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг ойлгоно.

Эдгээрийн хэрэгжилтийг төрийн эрх бүхий байгууллага хариуцах бөгөөд ялын гүйцэтгэлийн бодлоготой уялдуулан тухайн байгууллагын чиг үүргийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

1. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх;
2. Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хууль тогтоомжийг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх;
3. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг засаж хүмүүжүүлэх, хорих ангиас суллагдсан хүнийг нийгэмшүүлэх зэрэг болно.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь хууль сахиулах, хянан шийдвэрлэх, ялыг гүйцэтгэх чиг үүрэгтэй байгууллагын зүгээс олон

нийтийн оролцоо, хамтын ажиллагааны хүрээнд нарийн зохион байгуулалттай явуулж буй үйл ажиллагаа юм.

Эрх зүйн хүрээнд эрүүгийн ялын гүйцэтгэлийн бодлого дараах хэлбэрээр илэрнэ. Үүнд:

- хууль тогтоомжийг боловсронгуй болгох;
- удирдлага, зохион байгуулалт;
- дүрэм, журмыг өөрчлөх;
- практик үйл ажиллагаа.

Эрүүгийн ялын гүйцэтгэлийн бодлогын агуулгыг тусгах үндсэн хэлбэр нь эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тогтолцоо, үндэслэл, журмыг тогтоосон хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж юм.

Удирдлага, зохион байгуулалт нь хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх засаглал, хүний эрхийг хамгаалах байгууллага зэргээс дэвшүүлж буй гол үзэл санаа, шаардлагыг тусгасан баримт бичиг юм. Тухайлбал, хоригдлын эрх, эрх чөлөөг сахин хамгаалахын тулд хорих ангийн орчин, нөхцөлийг сайжруулахаас гадна хүнлэг харилцааг төлөвшүүлсэн байх шаардлагатай. Үүний тулд хорих ялыг сонгох хувилбартайгаар оноох чиглэлд эрүүгийн ялын бодлогыг хандуулах нь зүйтэй гэж Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалд тусгасан байна.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодлогыг тусгасан дараагийн хэлбэр нь хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх явцад дагаж мөрдөх нөхцөл, журмыг нарийвчлан тогтоож өгсөн төрийн эрх бүхий байгууллагаас гаргаж буй хэм хэмжээний акт юм.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодлогыг тодорхойлж буй дөрөв дэх хэлбэр нь эрүүгийн ялыг гүйцэтгэх ажиллагааг гардан хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллагын үйл ажиллагаа юм.

Олон улсад эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодлогын үндсэн чиглэлийг дараах байдлаар тодорхойлж байна:

- хорих байгууллагын орчин, нөхцөлийг олон улсын эрх зүйн стандартад нийцүүлэх;
- сонгох хувилбартай ялын хүрээг өргөжүүлэх;

- эрүүгийн ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн зүгээс тавих хяналтыг сайжруулах;

- хорих ангийн бүтэц, үйл ажиллагааг шинэ хэлбэрээр зохион байгуулах;

- нийгэмшүүлэх чиг үүрэгтэй албыг эрүүгийн ялыг гүйцэтгэх тогтолцооны бүтцэд байгуулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодлогын үндсэн агуулга нь ялын гүйцэтгэлийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжилтийг хангахад чиглэсэн зорилго, зорилт, зарчмыг онолын үндэслэлтэйгээр тодорхойлоход оршино.

Төрийн ялын бодлогын тогтолцоо нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн зүгээс хүлээх үүрэг, хариуцлагыг хуулиар нарийвчлан тогтоох, ялыг гүйцэтгэх ажиллагааг хангах, албадлагын арга хэмжээ хэрэглэх арга, хэрэгслийг боловсронгуй болгоход чиглэсэн төрийн байгууллагын нягт уялдаатай, нарийн зохион цогц ажиллагаа юм.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго, зорилт, зарчимд тавигдах гол шаардлага нь шинжлэх ухааны үндэслэлтэй байх, олон улсын стандартад нийцсэн байх, эрх зүйн хэм хэмжээтэй уялдсан байх, харьцангуй тогтвортой байх ёстой.

Эрүүгийн ялыг гүйцэтгэх бодлогын зорилго, зарчмыг хуулиар тогтоох ба бодлогын зорилго нь:

- эрүүгийн ял хэрэгжүүлэх ажиллагааг оновчтой бодлогын хүрээнд зөв зохион байгуулах замаар иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас сахин хамгаалах;

- гэмт хэрэг үйлдсэн этгээдийг засарч хүмүүжихэд эергээр нөлөөлөх орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

- гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг сахин хамгаалахад чиглэсэн хүмүүжлийн тогтолцоог бий болгох зэрэгт оршино.

Эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох, нийгэмшүүлэх чиглэлд төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон

нийтийн анхаарлыг хандуулах, суллагдсан хүнийг нийгэмшүүлэх ажлыг оновчтой, үр дүнтэй зохион байгуулах зорилтыг хангах учиртай.

Харин эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэтийн бодлого нь хорих байгууллагын үйл ажиллагааг ардчилсан тогтолцоонд шилжүүлэх, нийгмээс тусгаарлахгүй оноох ялын шинэ хэлбэрийг эрэлхийлж, шүүхийн практикт нэвтрүүлэх, засаж хүмүүжүүлэх чиглэлд олон нийтийн зүгээс үзүүлэх нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлэх зэрэг байна.

НҮБ-ын гишүүн орнууд эрүүгийн хууль тогтоомждоо дээрх зарчмыг баримталж, хорих ялаас татгалзан, хорихоос өөр төрлийн ялыг сонгон хэрэглэх, уг ялыг хэрэглэхдээ олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн нийгмийн өмнө хариуцлага хүлээх мэдрэмжийг нэмэгдүүлж, нийгмийн хэвийн амьдралд эргэж орох хэрэгцээ, зөрчил гаргагч, хохирогчийн хоорондын харьцааг хангах, үндэсний хууль тогтоомж, нийгмийн шударга ёсны шаардлагад нийцүүлж хуульчлах шаардлагатайг дурдсан байгаа нь ял эдлүүлэх ажиллагааны тогтолцоог илэрхийлж байна гэж үзэж болох юм.

2. Пробацын үйл ажиллагаа нь өөр хоорондоо уялдаа холбоо бүхий цогц арга хэмжээ болохын хувьд:

Олон улсад пробацын үйл ажиллагааг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хорихгүйгээр нийгэмд нь ял эдлүүлэх, нийгэмшүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ гэж үзэн дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

а) шүүхийн шат буюу гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдийг цагдан хорихгүйгээр зорчих эрхийг хязгаарлах, батлан даалтад өгөх зэргээр хяналт тогтоох арга хэмжээ;

Гэмт хэрэгт сэрдэгдэж буй этгээдийг цагдан хорих нь эцсийн бөгөөд зайлшгүй тохиолдолд хэрэглэх нь зүйтэй юм.

Цагдан хорихоос илүү түгээмэл арга хэмжээ болох нь барьцаа (бэлэн мөнгөний эсвэл баталгаа өгөх), гэрээсээ гарахгүй байх тухай мэдэгдэл өгөх (бичиг баримт хураан авах), нутаг дэвсгэр, оршин суугаа газрын хязгаарлалт (гэрийн хорио), төрийн байгууллагын цахим хяналтад байлгах зэргийг ашиглаж байна.

Дээрх арга хэмжээг зайлшгүй шаардлагатай эмнэлгийн үйлчилгээ авахаас бусад тохиолдолд тодорхой хүмүүстэй харилцах, чөлөөтэй зорчих,

тээврийн хэрэгсэл жолоодох, согтууруулах төрлийн зүйл хэрэглэх зэрэг эрхийг нь хязгаарлана.

НҮБ-ын 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн 16-р зорилтын хэрэгжилтийн амжилтыг үнэлэх нэг үзүүлэлт нь цагдан хоригдсон этгээд болон хоригдлын тоо байдаг.

2021 оны байдлаар дэлхий даяар 6 сая хүн цагдан хоригдож байгаагаас 46 орон, тухайлбал, Африк, Азид цагдан хоригдсон хүний тоо шүүхээс ял шийтгэгдэн ял эдэлсэн хүний тооноос илүү байжээ.

Олон улсад гэмт хэрэгт сэжиглэгдэж буй хүнийг цагдан хорихоос өөр арга хэрэгслийг хэрэгжүүлэхийн тулд батлан даалтад өгөх, цахим хяналтад байлгахад эмзэг бүлгийн буюу орон гэргүй, ядуу хүмүүст боломжгүй байгаа зэрэг хүндрэлтэй асуудал үүсгэж байна.

б) шүүхийн шийдвэр гарсны дараах буюу хорихоос өөр төрлийн ял оногдуулах, ял тэнссэн, хойшлуулсан болон эмнэлэг, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг гүйцэтгэх арга хэмжээ;

Судалгаанаас харахад хорихоос өөр төрлийн ял эдэлж байгаа ялтны тоо улс орон, бүс нутгуудад ялгаатай байна. Европ, Хойд Америкийн ихэнх орнуудад хорихоос өөр төрлийн ял эдэлж буй ялтны тоо хоригдлоос илүү байдаг. Тухайлбал, Европын Холбооны гишүүн 36 улсад 2022 оны нэгдүгээр сард пробацын хяналтад 1.76 сая гаруй хүн, өөрөөр хэлбэл 100 мянган хүнд дунджаар 202 хүн хяналтад байгаа нь хоригдлын (100 мянган хүнд ногдох хоригдлын тоо 102) тооноос бараг хоёр дахин их байна¹.

Пробацын хяналтыг Европын Холбооны 28 улсын 15 нь хар тамхитай холбоотой гэмт хэрэгт ял шийтгүүлсэн, Африк тивийн Гамби, Кени, Малави, Нигери, Танзани зэрэг оронд түгээмэл хэрэглэж байна Кени, Уганда, Танзани зэрэг улсад цалин олгохгүйгээр нийтэд тустай хөдөлмөр хийлгэх арга хэмжээ хорихоос өөр төрлийн ялын дийлэнх хувийг эзэлдэг ба цахим хяналт, гэрийн хорио, мөнгөн торгууль, эд хөрөнгө хураах, нөхөн сэргээх, нийгэмшүүлэх хөтөлбөрт хамрагдах, олон нийтэд үйлчлэх, нийтэд тустай хөдөлмөр эрхлэх зэрэг хамаарна.

в) хорих ял эдлээд суллагдсан буюу хугацааны өмнө суллагдсан этгээдэд хяналт тогтоох арга хэмжээ.

¹ www.Cep-probation.org.

Хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллах асуудал анх 1885 онд Францад үүссэн гэж үздэг. Энэ цагаас хойш Европын бусад орноор дэлгэрч улмаар хорих ялаас өмнө тэнсэн суллах институт нь дэлхийн ихэнх оронд хэрэглэгдэж байна¹.

Хорих ялаас хугацааны өмнө болон хугацаа дуусаж суллагдсан, ял тэнссэн, ял эдлэхийг тодорхой хугацаагаар хойшлуулсан этгээдэд тавих хяналтыг дэлхийн ихэнх оронд пробацын алба гүйцэтгэж байна. АНУ-д 2021 оны жилийн эцсийн байдлаар пробацын хяналтад 6.7 сая хүн байсны 4.6 сая хүн нь ял тэнссэн, ял хойшлуулсан, тэнсэн суллагдсан хүн байжээ.

Энэхүү тогтолцоо тус бүрийн гүйцэтгэх үүрэг, онцлогийн талаар судалгааны ажлын дараагийн бүлэгт дэлгэрэнгүй авч үзэх болно.

3. Пробац нь төр, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагаа, оролцоо, дэмжлэг дээр суурилсан хуулиар эрх олгогдсон байгууллагын гүйцэтгэж буй үйл ажиллагаа болохын хувьд:

Дэлхийн улс орон, өөрсдийн эрх зүйн тогтолцоо, нийгмийн хөгжлийн онцлогт тохируулан пробацын албыг нэршил, чиг үүрэг, харьяаллын хувьд өөр өөр хэлбэрээр байгуулан ажиллуулж байна. Тухайлбал, АНУ, Англи, Швед, Латви, Гүрж зэрэг улсад “Пробацын алба”, Норвег, Финлянд, Дани, Эстони зэрэг улсад “Хяналтын алба” гэсэн нэршилтэйгээр ажиллуулж байгаа бол харьяаллын хувьд Англи, Дани, Япон, Финлянд, Норвег, Латви, Чех, Эстони зэрэг улсад Хууль зүйн яаманд, АНУ, ХБНГУ, Унгар зэрэг улсад Шүүхэд, Голландад Прокурорын байгууллагад, Швед, Казакстан зэрэг улсад Хорих байгууллагад, Сингапур улсад Спорт, нийгмийн хөгжлийн яаманд тус тус харьяалагддаг.

1990-д оноос хойш хуучин социалист тогтолцоо бүхий улс орнуудад үүссэн нэг хүндрэл нь хорих ял эдлэгсдийн тоо ихэссэн, төсвийн зардал их байсны зэрэгцээ, шоронжсон буюу гэмт зан авир, төлөвшил бүхий нийгмийн давхарга, томоохон бүлэг хүмүүс гарч ирсэн явдал юм. Тиймээс гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг шоронжуулахгүй байх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор пробацын үйл ажиллагааг нэвтрүүлж эхэлсэн байдаг.

¹ Додонов В.Н. Сравнительное уголовное право. Общая часть под общ. ред. С. П. Щербы—М., Юрлитинформ, 2009. -С. 397, 448.

Дэлхийн улс орнуудад эрх зүйн тогтолцоо өөр хэдий ч пробацын үйл ажиллагаа, зорилго, ач холбогдлын хувьд ижил төстэй байдлаар хөгжиж иржээ.

Ихэнх улс орон пробацын үйл ажиллагааг төрийн бусад байгууллага, орон нутгийн засаг захиргааны нэгж, хувийн хэвшлийн болон сайн үйлсийн байгууллага, иргэд, сайн дурын ажилтны оролцоонд тулгуурлан зохион байгуулдаг бөгөөд тухайн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх, түүнчлэн пробацын албанаас заавал биелүүлэх нөхцөлийг даалгасан, эрхийг хязгаарласан үүргийг хэрэгжүүлэх нөхцөл болдог.

Зарим улс орны ял шийтгэлийн бодлого нь нийгэм, олон нийтийн аюулгүй байдлыг хангаж, гэмт явдлыг тогтоон барих, гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хууль зөрчихгүйгээр дагаж мөрддөг байх, нийгмийн эсрэг зан үйлийг өөрчлөх агуулгаар хэрэгжиж байгаа бөгөөд ялын бодлогодоо өөрчлөлт оруулсан жишээ бий. Тухайлбал, Сингапурт 1965 онд баримталж байсан ялын бодлого нь зөвхөн гэмт хэрэгтэнд оногдуулах шийтгэлийн арга хэмжээ¹ гэж үзэж байсан бөгөөд энэ нь дахин гэмт хэрэг үйлдэх явдлыг өндөр түвшинд хүргэсэн туршлага² гэж үзсэн байдаг. Тус улсын Шүүхийн шинэчлэлийн нэг асуудал нь нийгэм, олон нийтийн оролцоонд тулгуурласан ялын төрлийг ашиглах явдлыг дэмжсэнд оршиж байгаа ба 2006 оны 6 сард байгуулагдсан “Олон нийтийн шүүх”-ийн үйл ажиллагаа энэхүү нөхцөлийг нэмэгдүүлсэн байна.

Энэхүү шинэчлэлийн үзэл баримтлал нь шүүн таслах ажиллагааны болон “гэмт хэрэгтэн – хохирогч - олон нийт” гэсэн загварын тэнцвэрт байдлыг хадгалахад чиглэгдэж, ялын бодлогын нөхөн сэргээх ба хариуцлага үүрүүлэх, гэмт хэрэгтний эрх ба хохирогчийн зөрчигдсөн хэрэгцээг хангах, гэмт хэрэгтнийг үүрэгжүүлэх болон олон нийтийн аюулгүй байдлыг хангах зэрэг асуудлын тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн гэж үзэж болно.

Олон нийтийн оролцоонд тулгуурласан ял эдлүүлэх шинэ хандлага нь гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх төдийгүй хохирогчдын эрхийг хангасан бодлого болохыг Засгийн газар, иргэдийн зүгээс дэмжиж, Хууль зүйн

¹ Peter English, “Sentencing in Singapore” (1981) 23 Mal.L.R. 1, at p.24.

² www.prisons.gov.

яамнаас нийгэм-олон нийтэд оногдуулах хувилбарыг нэмэгдүүлж, хэд хэдэн чиглэлээр ажиллах болжээ. Тухайлбал:

- шаардлагатай эмчилгээ хийх (бэлгийн хүчирхийлэл, садар самуунтай тэмцэх ажлыг хэрэгжүүлэхэд сэтгэцийн эмчилгээ хийх);

- богино хугацаанд цагдан хорих (гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, эрхэлж буй ажлаас нь түдгэлзүүлэхгүйгээр долоо хоногоос илүүгүй хугацаагаар хорих);

- “day reporting center”-т хамруулах (гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийн өдөр тутмын үйл ажиллагаа, тогтмол мэдээлэл авч байх ба шаардлагатай тохиолдолд цахим хяналтыг хэрэгжүүлэх);

- олон нийтийн ажил хийлгэх; (40 хүртэлх цагаар хийлгэх, тухайлбал, бусдын бие, эрхтэнд гэмтэл учруулсан бол тухайн өвчтөний хагалгааг хийлгэхэд шаардлагатай үйлчилгээний ажилд оролцуулах);

- олон нийтийн үйлчилгээнд хамруулах шийдвэр гаргах (16-аас дээш насны гэмт хэрэгтэнд төлбөр төлөхийг шаардан, сайн дурын үйлчилгээний байгууллагад 40-340 цагаар ажиллуулах);

- тусгайлсан хөтөлбөрт хамруулах (шүүхээс оногдуулсан хугацаанд тухайн хүний зан үйл, хандлагыг өөрчлөх, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн 12-24 сарын хөтөлбөрт хамруулах) зэрэг ажлыг хэрэгжүүлж байна.

Пробац нь эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны нэгэн хэсэг болон оршсоор байгаа аль ч улс орны хувьд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн шалтгаан, нөхцөлийг судлах, хорих ялаас татгалзах, нийгмийн дунд ял шийтгэлийг эдлүүлэх аргыг одоо ч эрэлхийлсээр байгаа билээ.

Пробацын үйл ажиллагааг хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад хоригдлыг гэмт хэрэгтэн бие хүн болж өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх, улмаар нийгмийн харилцаанаас тусгаарлахгүйгээр гэмт зан үйлийг өөрчлөх, нийгмийн амьдралд дасан зохицох, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хорих ялын өндөр зардлыг багасгах зорилгоор хэрэгжих эхэлсэн гэж үзэж болно.

Дэлхий улс орнуудад хорих газраас суллагдсан хүмүүст чиглэсэн төрийн бодлого үндсэн хоёр хэлбэртэй байна. Үүнд:

1. Нийгмийн хяналтын хэлбэр (Social control of criminals);

2. Нийгэмд амьдрахад нь дэмжлэг үзүүлэх хэлбэр (Rehabilitation of criminals).

Энэхүү хоёр хэлбэр нь тухайн улсын хөгжлийн чиг баримжаатай холбоотой хандлагаар илэрхийлэгддэг. Жишээ нь: нийгмийн хяналт нь хорих газраас суллагдсан хүмүүсийг “засаршгүй хүмүүс” гэж үзээд “рицедив гэмт хэрэгтэн” хэмээн нэрлэж, түүнтэй хийх тэмцлийг чангатгадаг. Хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэж байгаа нь хууль тогтоомжийг үл ойшоож, засарч хүмүүжихийг хүсэхгүй байгааг илтгэн харуулах шалгуур гэж үзэж суллагдсан хүмүүст нийгмийн зүгээс тавих хяналт илүү чанга байх ёстой бөгөөд ингэснээр дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж чадна гэж үздэг.

Нөгөө хандлага нь либерал баримжаатай барууны орнуудад хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн сэтгэл зүйг эмчлэх, нийгмийн туслалцаа үзүүлэх ажлын үндэс 1970-аад оноос эхлэн ул суурьтай хөгжиж эхэлжээ. Энэ нь гэмт хэрэгтнийг нийгэмд дахин засаж, хүмүүжүүлж болдог, ингэхийн тулд суллагдсан хүмүүст туслалцаа дэмжлэг хэрэгтэй гэсэн хүмүүнлэг үзэлд тулгуурладаг.

Орчин үед Европын холбоо зэрэг бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагын ардчилсан хүмүүнлэг иргэний нийгмийг баримжаалан хөгжиж байгаа улс орнуудад хорих ял эдлээд суллагдсан хүмүүст дэмжлэг үзүүлэх төрийн бодлого илүү үр дүнтэйг зөвлөж, гишүүн улс орнууддаа энэхүү ажлын стандартыг тогтоох шаардлага тавьж байна¹.

Хорих байгууллагад ял эдэлж байгаа хоригдол суллагдан гарсны дараа учрах бэрхшээлийн талаар асуулгад ихэнх нь “хорихоос суллагдахад бэрхшээл ихтэй байдаг, нэн ялангуяа тэднийг амьдралд хүлээн авах, хэн нэгэнтэй үл ойлголцох байдал бий болно, ажил олдохгүй байх” гэсэн айдастай байхад, иргэд эсрэгээр суллагдсан хүмүүсийн талаар сөрөг төсөөлөл, хандлагатай байна.

Иймд манай улсад хорих байгууллагаас суллагдсан хүнийг нийгэмшүүлэхэд нийгмийн хариуцлагаа ухамсарласан аж ахуйн нэгж, байгууллагаар дамжуулан ажилд зуучлах ажлыг засаг захиргааны болон

¹ ХЗҮХ. Судалгааны тайлангийн эмхэтгэл. - УБ., 2012. 663 дахь тал.

төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын идэвх санаачилгаар дамжин хэрэгжих ёстой гэж үзлээ.

Гурав. Пробац нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж буй үйл ажиллагаа:

Пробацын үйл ажиллагаа нь хорихоос өөр төрлийн ялаар шийтгэгдсэн, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн, хорих байгууллагаас суллагдах дөхсөн, түүнчлэн ял эдлээд суллагдсан иргэдэд туслалцаа үзүүлэхээс гадна ажилд зуучлах, санхүүгийн ухаанд суралцуулах, нийгэмшүүлэх зорилго бүхий хөтөлбөрт хамруулах, боловсрол, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт явуулах, хөдөлмөрийн биржтэй холбож өгөх зэрэг туслалцаа үзүүлж, хувийн бичиг баримттай болоход туслах, дахин гэмт хэрэг үйлдэх зан үйлээс татгалзуулах, урьдчилан сэргийлэх, нийгмийн зохист амьдралд ороход туслалцаа үзүүлэхэд голлон чиглэгддэг.

Пробацын албанд ихэвчлэн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, социологич зэрэг мэргэжлийн хүнийг ажиллуулдаг байна.

ХБНГУ-ын Пробацын албанд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн дараах үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- зөвлөгөө өгч харилцан туслах;
- хорих ял эдэлж байгаа хоригдолтой холбоо тогтоох;
- гэр бүл, асран хамгаалагчаар нь дамжуулан нөлөөлөх;
- эмчилгээний сэдэл өгөх;
- донтох зуршлаас татгалзуулах (архи, тамхи, мансууруулах бодисын хамаарал г.м);
- эмчилгээнд хамруулах;
- төлбөрөө төлөх хөтөлбөр боловсруулахад үзүүлэх дэмжлэг;
- төлбөрөө барагдуулах төлөвлөгөө боловсруулах;
- төлбөрийн зөвлөгөө өгөх төвтэй холбоо тогтоох;
- ажлын байр хайх (сургалт, давтан сургалтад дэмжлэг үзүүлэх);
- амьдрах орон сууц хайхад дэмжлэг үзүүлэх;
- орон сууцны төсөл, хөтөлбөрт хамрагдахад туслах;

- эдийн засгийн бэрхшээлтэй холбоотой зөвлөгөө, тусламж;
- хүчирхийллийн эсрэг сургалт;
- хорих ангиас суллагдах бэлтгэл зөвлөгөө;
- урьдчилан саатуулах хувилбарыг бэлтгэх;
- хорихоос өөр төрлийн ялаар орлуулахад түлхэц үзүүлэх;
- бусад байгууллагуудтай хамтран ажиллах;
- ажил гүйцэтгэх, чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөл байдлыг сайжруулах;

- орон нутгийн зүгээс ялын хэрэгжилтэд оролцох (жишээ нь: донтолт, орон гэргүй байдал, урьдчилан сэргийлэх, нийгмийн халамж гэх мэт).


Түүнчлэн Япон¹, Англи, АНУ² зэрэг орны туршлага нь хорих ял эдлүүлэхэд гарах зардлаа хэмнээд зогсохгүй ял шийтгэгдэгсдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх ажилд тулгамдаж буй сөрөг асуудлыг шийдэж чадсан байна.

Пробацын үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж үзвэл дараах зураглал бий болж байна.

¹ Япон улсад 1995 онд “Гэмт хэрэг, зөрчил гаргагчийг нийгэмшүүлэх тухай” хууль, 1996 онд “Сайн дурын пробацын албаны тухай” хуулийг баталсан бөгөөд тус улсын Хууль зүйн яамны харьяанд Нийгэмшүүлэх буюу нийгмийн ажлын товчоо ажилладаг.

² АНУ-д Halfway house байгууллага нь хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлэх, суллагдсаны дараа эргэн нийгэмшихэд нь дэмжлэг үзүүлдэг бөгөөд хагас хяналттай, хууль сахиулах байгууллагын туслалцааг авах хэлбэрээр хамтран ажилладаг, тусгайлсан институт байна.

Зураг 1. Пробацын нийтлэг үйл ажиллагааны зураглал.



Пробацын мөн чанар, ач холбогдол:

Судлаачийн зүгээс пробацын үйл ажиллагааны мөн чанарыг нь дараах байдлаар илэрнэ гэж үзлээ. Үүнд:

1. Эрүүгийн эрх зүйн хүрээнд ял, албадлагын арга хэмжээний төрөл, хэлбэр;

Эрүүгийн хууль тогтоомжоор гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг тогтоодог бөгөөд пробац нь тухайн ял, шийтгэлийг эдлүүлэх ажиллагааг зохион байгуулах хэлбэр байна.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэжигтэн, яллагдагчийн хувийн байдлыг тодорхойлон, шүүхээс цагдан хорихоос бусад таслан сэргийлэх арга хэмжээг авах, хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг оногдуулахад чиглэсэн ажиллагаа;

Шүүхээс зайлшгүй хорихгүйгээр нийгэм, ар гэрийн хүрээнд байлган, сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлүүлэх замаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, шоронжих явдлаас сэргийлэхэд онцгой анхаарах нь чухал юм.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй дэх гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан нийгмээс тусгаарлахгүйгээр ял эдлүүлэх хяналт, нийгэмшүүлэх тогтолцоо;

Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны үндсэн зорилго нь ялын зорилгыг хангахаас гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч ялын үр нөлөөг хангах явдал байдаг. Шүүхээс зайлшгүй хорихгүйгээр нийгэм, ар гэрийн хүрээнд байлган, сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлүүлэх замаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, шоронжих явдлаас сэргийлэхэд онцгой анхаарах нь чухал юм.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй дэх гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулсан нийгмээс тусгаарлахгүйгээр ял эдлүүлэх хяналт, нийгэмшүүлэх тогтолцоо;

Эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны үндсэн зорилго нь ялын зорилгыг хангахаас гадна гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг авч ялын үр нөлөөг хангах явдал байдаг.

5. Криминологийн үүднээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нийгэм, эрх зүйн шинжтэй арга хэмжээ;

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээг хэрэгжүүлснээр нийгэмд үйлдэгдэж буй гэмт хэргийг бууруулах, улмаар иргэдийн аюулгүй орчинд аж төрөх нөхцөл бүрдэх юм.

6. Нийгмийн ажлын үүднээс гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэмт зан үйлийг засах, нөхөн сэргээх, эмнэлэг, халамжийн үйлчилгээ.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэрэгцээг тодорхойлсноор халамжийн болон эмнэлэг, сэтгэл зүй, нийгэмшүүлэх үйлчилгээг үзүүлэн, гэмт зан үйлээс татгалзуулах, иргэншсэн бие хүн болгон төлөвшүүлэх нь чухал юм.

ДҮГНЭЛТ

1. Хоригдлын тоо багасах;

Дэлхийн улс орнуудын хэмжээнд хоригдлын тоо нэмэгдэн, 2002 онд 8 сая байсан бол 2020 оны судалгаагаар цагдан хоригдсон, захиргааны журмаар баривчлагдсан хүн орохгүйгээр 11 сая хүрсэн байна. Үүнд 2000 оноос хойш эмэгтэй хоригдлын тоо 50 хувиар нэмэгдэн 2020 онд 700,000 мянга давж, 19.000 мянган хүүхэд хорих ангид төрж, ээжтэйгээ хамт хоригдсон байна. Түүнчлэн 2020 онд 410,000 насанд хүрээгүй хүүхэд хорих ял эдэлж, 1 сая хүүхэд баривчлах шийтгэл эдэлж, 3 сая хүүхэд цагдан хоригджээ. Дэлхий даяар дайны олзлогсдыг тооцохгүйгээр 11 сая гаруй хүн хорих ял эдэлж байгаа нь хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорих ял оногдуулсан энэ бол дээд амжилт болж байна. Дэлхийн 102 улсад хорих ангийн багтаамж 100 хувиас илүү гарсан байна¹. Дээрх тоо баримт нь аливаа улс оронд хоригдлын тоог бууруулах асуудал чухлаар тавигдсан ба үүнийг шийдвэрлэх үндсэн арга хэмжээ нь пробацын хяналтад байлгах явдал юм гэж хүлээн зөвшөөрчээ.

2. Хорих ял эдлүүлэх ажиллагаанд гарч буй зардал буурах;

Пробацын үйл ажиллагаа нь хоригдлыг хугацаанаас нь өмнө суллах бодлогын нэгэн адил хоригдолд зориулсан төсвийн зардлыг хэмнэхэд оршдог. АНУ-ын хувьд пробацыг өргөн хэрэглэдэг орны нэг зүй ёсоор тооцогддог бөгөөд энэ нь бусад ял, түүний дотроос хорих ялыг бодвол эдийн засгийн хувьд харьцангуй хэмнэлтэй ялын төрөлд тооцогддог. Тухайлбал, тус улсын татварын албаны хийсэн тооцоогоор хорих газарт ял эдэлж байгаа 1 хоригдолд жилд 20.000 ам.доллар зарцуулдаг бол пробацын албаны хяналтад байгаа 1 хүнд жилд 1000 ам. доллар зарцуулдаг байна². Харин Канад улсад хоригдлын зардал 52,953 доллар, пробацын хяналтад жилд ойролцоогоор 10,951 доллар зарцуулж байна.

Монгол Улсад 2022 оны байдлаар хоригдолд ногдох өдрийн дундаж зардал 24.380 төгрөг буюу жилд 8.898.941 төгрөг байгаа ба хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтанд ногдох өдрийн дундаж зардал 2704 төгрөг буюу жилд 987.002 төгрөг байгаа нь хорих ял эдлүүлэх зардлаас

¹ www.Cep-probation.org.

² Аккулев А.Ш. Отдельные вопросы probation // Научный журнал: Вестник Евразийского гуманитарного института 2010. №4.

даруй 89 хувиар бага байна¹. Хэдийгээр хорих ял эдлүүлэх ажиллагаанд гарах зардлыг хэмнэх нь зүйн хэрэг боловч дэлхийн 54 орны хорих ял эдлүүлэх төсөв дотоодын нийт бүтээгдэхүүний 0,3 хувиас бага, түүнчлэн ихэнх зардал нь алба хаагчдын цалин, хангамжид зарцуулж байгаа нь хоригдлын хүнс, ахуй нөхцөл, нийгэмшүүлэх ажил, эмнэлгийн үйлчилгээнд маш бага зардал зарцуулж буй нь зайлшгүй анхаарал хандуулах асуудал гэж үзэж байна.

3. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх ажлын үр нөлөө сайжрах;

Нийгэмшүүлэх ажлыг зөвхөн хорих ял эдлэгсдийн дунд бус гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлэг, хөдөлмөр, сэтгэл зүй, халамжийн үйлчилгээ зэргийг цогц байдлаар хүргэснээр амьдралын чадавх дээшлэх, зөв амьдрах хандлага төлөвших нөхцөл бүрдэнэ.

4. Давтан рицедив гэмт хэрэг буурах;

Ялын бодлогын шинэчлэлийн нэг хэсэг болох хорих ял биечлэн эдлэх явдлыг багасган, гэмт хэрэг үйлдсэн хүний гэм бурууг өөрөөр нь ухамсарлуулан, хөдөлмөр эрхлүүлж хохирлоо нөхөн төлүүлэх, бусад хоригдлоос суралцан мэргэшсэн гэмт хэрэгтэн болгохгүйн тулд авч байгаа шинэлэг арга хэмжээ юм.

5. Ял эдлүүлэх ажиллагаа дахь олон нийтийн оролцоог сайжрах;

Пробацын үйл ажиллагаанд төр, төрийн бус байгууллага, иргэд, тухайлан ажил олгогчдыг өргөнөөр татан оролцуулснаар нийгэмшүүлэх ажлын үр нөлөө сайжирч, ялын зорилго хангагдах боломж бүрдэх юм. Японд жирийн иргэдийн дундаас сайн дурын ажилтныг ажиллуулж байгаа нь үр дүнтэй байсан ба 2017 онд 47,909 сайн дурын ажилтан ажиллажээ.

6. Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлын нөхөн төлөлт сайжрах;

Пробацын үйл ажиллагааны гол онцлог нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг зайлшгүй хөдөлмөр эрхлүүлж, учруулсан хохирлоо нөхөн төлүүлэхэд оршиж байгаа нь тухайн этгээд нэг талаас хөдөлмөрийн дадлага эзэмших, ажлын байртай болохоос гадна гэмт хэргийн улмаас учруулсан хохирол нөхөн төлөх байдал эрс сайжирдаг гэж үздэг байна.

¹ Хууль зүй, дотоод хэргийн яам. Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтэд шаардагдах зардлын тооцоо. -УБ., 2020. 17 дахь тал.

Нэгтгэн дүгнэж үзвэл, Монгол Улсад хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд нийгэм-олон нийтийн оролцоонд тулгуурласан хэлбэрийг сонгож, эрх зүйн зохицуулалт, тогтолцооны үндсийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд пробацын үйл ажиллагааг жишиг хэлбэрээр бий болгон хөгжүүлэх, энэ үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийг татан оролцуулах боломжтой гэсэн дүгнэлтэд хүрлээ.

---o0o---